

"МОНХ ДААТГАЛ" ХХК

1. Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг санаатайгаар бүрдүүлсэн;
2. Даатгуулагч даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
3. Даатгалын гэрээнд тусгагдаагүй шалтгаан, эрсдлийн улмаас хохирол гарсан;
4. Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
5. Техник тоног, төхөөрөмжийн ашиглалтын горим зөрчсөн, даац, ачаалал хэтрүүлснээс үүссэн хохирол;
6. Даатгалын зүйлийн өмчлөлд өөрчлөлт орсон талаар даатгагчид 14 хоногт багтаан мэдэгдээгүй үед учирсан хохирол;
7. Даатгалын зүйлийг согтуугаар жолоодох, гэмт хэргийн зорилгоор болон хууль бусаар ашиглаж явах үед учирсан хохирол;
8. Нэмэлт эрсдэлээр даатгуулаагүй автотээврийн хэрэгсэл хулгайд алдсан болон дээрэмдүүлсэн, тэдгээрээс үүдэн гарсан хохирол;
9. Нэмэлт тоноглолыг тусгайлан үнэлж даатгуулаагүй тохиолдолд нэмэлт тоноглолд учирсан хохирол
10. Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна үүссэн хохирол;
11. Зорчигчийн хамгаалалтын бүс хэрэглээгүйн улмаас тээврийн хэрэгсэлийн салхины шилэнд учруулсан хохирол;
12. Тээврийн хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах (Ан ав хөөх, уралдаанд орох, зөвшөөрөлгүй хүн тээвэрлэх...г.м);
13. Дугуйн гадуур бүрээс, олгой, механик эвдрэл болон мотор цохисон, тээврийн хэрэгслийн эд ангийн хэвийн элэгдэлүүд;
14. Даатгуулагч байгууллагатай хөдөлмөрийн буюу ажил гүйцэтгэх гэрээгүй хүн жолоодож явах үед гарсан аливаа хохирол;
15. Энэхүү гэрээний дагуу хураамж төлөх болон даатгалын тохиолдлыг баталгаажуулах үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол.